



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: foreign@mojha.gov.mn,
Вэбсайт: www.mojha.gov.mn

2020. 10. 20 № 1/1299
танай 2020. 10.01-ны № 23 -г

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Б.БАЯРСАЙХАН
ТАНАА

Танаас ирүүлсэн 2020 оны “Асуулт тавих тухай” 23 тоот албан бичигтэй танилцаж, холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.


Хавсралт 6 хуудастай.



Х.НЯМБААТАР

151601128
Doc.yam a5.2020


Хууль зүй, дотоод хэргийн сайдын
2020 оны 10 дугаар сарын 20-ны
өдрийн 11/2020 тоот албан
бичгийн хэвсрэлт



1. Монгол Улсын хэмжээнд үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээллийн талаар:

Монгол Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 2017-2019 онд 3341, 2020 оны эхний 09 сарын байдлаар 845, нийт 4186 гэмт хэрэг бүртгэгдсэн нь нийт хэргийн 3.5 хувийг эзэлж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийг нийт бүртгэгдсэн гэмт хэрэгтэй харьцуулбал:



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2017 онд үйлдэгдсэн гэмт хэрэг нийт хэргийн 4.0 хувийг эзэлж байсан бол 2018 онд 3.0, 2019 онд 2.8 хувь болж тус тус буурсан бол 2020 оны эхний 9 сард 5.0 хувь болж өссөн байна.


Энэ төрлийн гэмт хэргийн 54.1 хувь нь Улаанбаатар хотод, 45.9 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ.



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийг Эрүүгийн хуульд заасан бүлгээр авч үзвэл, нийт бүртгэгдсэн 4186 гэмт хэргийн 3786 буюу 90.4 хувийг Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 311 буюу 7.4 хувийг Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг эзэлж байна.

Гэмт хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, төрлөөр нь авч үзвэл:

Гэмт хэргийн төрөл	2017 он	2018 он	2019 он	2020.09
Хүний амьд явах эрхийн эсрэг	12	12	13	16
Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг	1102	998	913	773
Үүнээс: Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх	198	210	207	83
Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг	166	47	54	44
Үүнээс: Хүчиндэх	56	38	50	39
Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг		5	2	3
Хүүхдийн эсрэг		7	2	2
Эрүүл мэндийн эсрэг			1	
Бусад	6	1		7



Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн нийт хэргийн 1748 буюу 41.7 хувь нь согтуугаар үйлдэгджээ.

Цагдаагийн байгууллагад 2017-2019 он, 2020 оны эхний 9 сарын байдлаар Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих зөрчил нийт 27336 бүртгэгдсэн байна. Зөрчил 2017 онд 4369, 2018 онд 5821 бүртгэгдэж, 1452 нэгжээр буюу 33.2 хувиар, 2019 онд 8962 бүртгэгдэж, 3141 нэгжээр буюу 54.0, 2020 оны эхний 9 сард 8184 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 1657 буюу 25.4 хувиар тус тус өсчээ.

2. Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн тоон мэдээллийн талаар:

Улсын хэмжээнд 2017-2019 онд 4695, 2020 оны эхний 9 сарын байдлаар хүүхэд хохирсон 878, нийт 5573 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Үүнээс 3726 буюу 66.9 хувь нь Улаанбаатар хотод, 1847 буюу 33.1 хувь нь орон нутагт тус тус бүртгэгджээ.

Гэмт хэрэгт өртөж хохирсон хүүхдийн тоог харьцуулбал:



Гэмт хэргийг Эрүүгийн хуулийн зүйл, анги, хохирсон хүүхдийн насны байдлаар авч үзвэл:



3. Хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаарх бүртгэл хөтлөлт, мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтийн талаар:

Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сангийн дэмжлэгтэй “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” төслийн хүрээнд “Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн нэгдсэн сан” үүсгэн, 2018 оны 04 дүгээр сараас эхлэн ажиллуулж байна.

Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийн сан нь цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, мэдээлэл, өргөдөл, гомдол, зөрчил, гэмт хэргийн болон гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлсэн тусламж үйлчилгээ, хүчирхийлэл үйлдэгч этгээдэд авсан арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэсэн, Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байранд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэр бүлийн гишүүд, хүүхэд бүртгэгдсэн талаарх мэдээллийг агуулсан дахин ашиглах боломжтой цахим мэдээллийн бааз юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/25 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийллийн талаарх статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх журам”, “Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох журам”-ыг тус тус батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.


Цагдаагийн байгууллагын мэдээллийн санд энэ төрлийн гэмт хэргийн улмаас 2017-2019 он, 2020 оны эхний 9 сарын байдлаар нийт 3617 иргэн хохирсон мэдээлэл бүртгэгдсэн бөгөөд үүнээс 3307 буюу 91.4 хувь нь эмэгтэй хүн, 178 буюу 4.9 хувь нь хүүхэд байна.

Хохирогчдын хүйс, нийгмийн байдлаар авч үзвэл:




Мөн гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон эхнэр 1905, хамтран амьдрагч 723, нөхөр 192, төрсөн хүүхэд 130, төрсөн ах, эгч 27, дагавар хүүхэд 110, төрсөн эцэг, эх 95, төрсөн дүү 30, хадам эцэг, эх 23, үрчилж авсан хүүхэд 5, өвөг эцэг, эмэг эх 3, бусад хүн 374 байна.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдыг гэр бүлийн хамаарлын байдлаар авч үзвэл:




Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэгт 2017-2019 онд 22, 2020 оны эхний 9 сарын байдлаар 12, нийт 34 хүний амь нас хохирсон бол гэмтсэн хүн 2017-2019 онд 2343, 2020 оны эхний 9 сард 721, нийт 3064 байна.

Гэмтсэн болон нас барсан иргэнийг оноор нь харуулбал:



2017-2019 он, 2020 оны эхний 9 сарын байдлаар энэ төрлийн гэмт хэрэгт нийт 4367 иргэн холбогдон шалгагдсан ба 2017 онд 1269 байсан бол 2018 онд 77 нэгжээр буюу 6.1, 2019 онд 148 нэгжээр буюу 12.4 хувиар тус тус буурсан. Нийт холбогдогчдын 2210 буюу 50.6 хувь нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн байна.



4. Түр хамгаалах байрны нөхцөл байдал, үйлчилгээ үзүүлсэн тоо баримтын талаар:

Улсын хэмжээнд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг болзошгүй аюул эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиг үүрэгтэй түр хамгаалах 15 байр, нэг цэгийн үйлчилгээний 18 төв үйл ажиллагаа явуулж байна.

Үүнээс цагдаагийн байгууллагын хэмжээнд түр хамгаалах 4 байр үйл ажиллагаа явуулж байгаагаас Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяанд 1, Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын харьяанд 2, Төв аймаг дахь цагдаагийн газрын харьяанд 1 байна.

Мөн Завхан аймаг, Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын харьяанд тус бүр 1 нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулдаг.

Цагдаагийн байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулдаг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд энэ оны эхний 9 сарын байдлаар 210 хүүхэд, 73 эрэгтэй, 82 эмэгтэй, нийт 365 иргэний аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүйн болон эрх зүйн туслалцаа, холбон жуулчлах үйлчилгээг тус тус үзүүлсэн байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Азийн хөгжлийн банк, Нийслэлийн цагдаагийн удирдах газраас Монгол Улсын стандарт MNS 6040:2019 “Хохирогчийг түр хамгаалан байрлуулах үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага”-д нийцсэн ажил, үйлчилгээг гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүнд үзүүлэх, тэдний хууль ёсны эрх ашиг сонирхлыг хамгаалах ажлыг баталгаатай хүргэх зорилгоор Азийн хөгжлийн банкны 1.5 сая долларын хөнгөлөлттэй зээлээр Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвийн хашаанд Түр хамгаалах байрыг барих ажлыг эхлүүлээд байна.

5. Гэр бүлийн болон бэлгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх мэдээлэл, тоо баримтын талаар:

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, хохирогч, түүний гэр бүлийн бусад гишүүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх нэгжийг Цагдаагийн ерөнхий газрын даргын 2019 оны А/301 дүгээр тушаалаар байгуулан, ажиллуулж байна.

Цагдаагийн байгууллагаас Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, НҮБ-ын Хүн амын сан, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран гэр бүлийн хүчирхийлэл, түүний хор уршгийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлж, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч болон хүчирхийлэлд өртөгчийн зан төлвийг өөрчлөх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх, нуугдмал гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх, хохирогчийн эрх, хууль ёсны ашиг, сонирхлыг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээхэд дэмжлэг үзүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор энэ оны 03 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд “Хайр өвтгөдөггүй” соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг 2 үе шаттайгаар зохион байгуулсан.

Арга хэмжээний хугацаанд гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг өнгөрсөн оны мөн үеэс 4.5 хувиар буурч, илрүүлсэн зөрчил 68.1, баривчлагдсан хүн 50.3 хувиар тус тус өссөн үр дүн гарсан.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-33.1.7 дахь хэсэгт заасан 6 төрлийн үйлчилгээг Эрүүл мэндийн болон Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам хариуцан хэрэгжүүлдэг тул үйлчилгээний талаарх холбогдох мэдээлэл, тоо баримтыг тухайн байгууллагаас авч болно.

6. Сэтгэл засал, хууль эрх зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлсэн тоон мэдээллийн талаар:

Цагдаагийн байгууллагын харьяанд үйл ажиллагаа явуулдаг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд 2020 оны эхний 09 сарын байдлаар 210 хүүхэд, 73 эрэгтэй, 82 эмэгтэй, нийт 365 иргэний аюулгүй байдлыг хангах, сэтгэл зүйн болон эрх зүйн туслалцааны үйлчилгээг тус тус үзүүлсэн.

7. Хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлсэн талаарх мэдээлэл, судалгааны талаар:

Цагдаагийн байгууллагаас гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй эрсдэлтэй 2018 онд 1360, 2019 онд 10238, 2020 оны эхний 9 сарын байдлаар 9676, нийт 21274 иргэнийг илрүүлэн, аюулын зэргийн үнэлгээ хийж, 13828 буюу 65.1 хувийг төрөл, садан, ойр дотны хүний хамгаалалтад, 3616 буюу 17.0 хувийг түр хамгаалах байранд, 2127 буюу 10.0 хувийг нэг цэгийн үйлчилгээний төвд, 617 буюу 2.9 хувийг эмнэлгийн байгууллагад, 1086 буюу 5.0 хувийг асрамж, халамжийн байгууллагад тус тус хүлээлгэн өгсөн болохыг танилцуулъя.

--oOo--